



МОНГОЛЫН
ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО



ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны 07 дугаар сарын 04

Улаанбаатар хот





ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.1 Холбооны Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:	1.1.1.Хуульчдын Холбооны Зөвлөлийн хурлыг зохион байгуулах, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, тайлагнах	Улирал тутам	Зөвлөлийн хурлын үйл ажиллагаа хэвийн явагдаж, хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан байна.	Хуульчдын холбооны зөвлөл нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчдын холбооны дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, цаг үеийн асуудлаар нийт 3 удаа ээлжит болон ээлжит бус хурал хийж, 20 асуудал хэлэлцэн, хэлэлцсэн асуудлын хүрээнд нийт 24 тогтоол гаргасан.
	1.1.2.Холбооны Ерөнхийлөгч, Тамгын газрын даргын тушаал шийдвэрийн биелэлтийн мэдээ, тайлан гаргах	Улирал тутам	Удирдлагыг мэдээллээр хангасан байна.	2023 оны эхний хагас жилийн байдлаар Ерөнхийлөгчийн тушаал 182, Тамгын газрын даргын Б тушаал 25, А тушаал 18 батлагдан гарсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар тушаал шийдвэрийн биелэлтийг нэгтгэн ажилласан.
	1.1.3.Тамгын газрын Удирдлагын зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах	Тухай бүр	Тамгын газрын төлөвлөгөөнд тусгагдсан болон удирдлагын үүрэг даалгаварын биелэлт хэрэгжүүлсэн байна.	Тамгын газрын Удирдлагын зөвлөл нь Тамгын газрын даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 2023 оны эхний хагас жилд 5 удаа хуралдаж ажилтнуудад үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийн хангуулж ажилласан.
	1.1.4.Хуульчдын Холбооны жилийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулах / хороодоос ирүүлсэн саналыг нэгтгэн/	Тухай бүр	МХХ-ны тухайн жилийн төлөвлөгөөг батлуулсан байна.	Чиг үүргийн болон сайн дурын хороодоос ирүүлсэн саналыг тусган боловсруулж холбооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Зөвлөлийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 16 дугаар тогтоолоор батлуулсан.
	1.1.5.Хуульчдын Холбооны төлөвлөгөөний биелэлт, хороодын тайланг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх, хэлэлцүүлэх	Тухай бүр	Төлөвлөгөөний биелэлт, тайлан, мэдээг хууль, дүрэмд заасан хугацаанд нэгтгэн, тайлагнасан байна.	Хуульчдын холбооны 2023 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэсэн, чиг үүргийн болон сайн дурын хорооны эхний хагас жилийн тайлан, мэдээг тус тус нэгтгэсэн.
	1.1.6.Тамгын газрын жилийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах	01 сар	Тамгын газрын төлөвлөгөөг батлуулсан байна.	Хуульчдын холбооны Тамгын газрын 2023 оны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
<p>1.1</p> <p>Холбооны Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:</p>	<p>1.1.7. Тамгын газрын жилийн төлөвлөгөөний биелэлтэд тухай бүр хяналт тавьж, төлөвлөгөөний хэрэгжилт, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох газарт хүргүүлэх, тайлагнах</p>	<p>Хагас, бүтэн жил</p>	<p>Тамгын газрын төлөвлөгөөний хэрэгжилт, мэдээ, тайлан хууль, дүрэмд заасан хугацаанд нэгтгэн, тайлагнасан байна.</p>	<p>Хуульчдын холбооны Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлт, хороодын бичмэл тайлан, тоон мэдээ, хороодын хурлын мэдээ, тушаал шийдвэрийн биелэлт, гэрээний бүртгэл зэргийг нэгтгэсэн бөгөөд Хяналтын зөвлөлд дүрэмд заасны дагуу тайлагнахаар хүргүүлсэн.</p>
	<p>1.1.8. Тамгын газрын санхүүгийн тайланг гаргаж холбогдох газар, /Хяналтын зөвлөл/-д хүргүүлэх</p>	<p>Хагас, бүтэн жил</p>	<p>Санхүүгийн тайлан, мэдээ Хуульд, дүрэм, журамд заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлж, тайлагнасан байна.</p>	<p>2023 оны хагас жилийн байдлаар НДШ-ийн тайланг сар Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст тайлагнаж хүргүүлсэн. 2023 оны 1 дүгээр улирлын Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын тайланг ЧД-ийн татварын хэлтэст 2023 оны 04 дүгээр сарын 20-ны дотор тайлагнасан.</p> <p>2022 оны, 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж Хяналтын зөвлөлд танилцуулахад бэлэн болсон.</p>
	<p>1.1.9. Холбооны Ерөнхийлөгч болон Тамгын газрын даргын олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа, уулзалт, өдөр тутмын ажилд туслах, хэвийн ажиллах нөхцөлөөр хангах</p>	<p>Жилдээ</p>	<p>Холбооны удирдлагуудын өдөр тутмын ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна.</p>	<p>Хуульчдын холбооны Тамгын газар нь үйл ажиллагаагаа шуурхай явуулах зорилгоор тухай бүрийн ажлын гүүгл календарт ашиглан төлөвлөж гадаад дотоодын байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, хуульчид, иргэдийг хүлээн авч хүсэлтийг сонсож, шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p>2023 оны эхний хагас жилд зохион байгуулсан томоохон уулзалтуудаас дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Ерөнхийлөгч; • Монгол Улсын Их Хурлын дарга; • Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга; • Шүүхийн ерөнхий зөвлөл; • Цагдаагийн ерөнхий газар; • Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл; • Хууль зүй, дотоод хэргийн сайд; • Байгаль орчин, аялал жуулчлалын сайд; • Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Эвлэрүүлэн Зуучлагчдын зөвлөл; • Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх; • Азийн сан; • АНУ-ын худалдааны яамны дэргэдэх арилжааны эрх зүйн хөгжлийн хөтөлбөр; • Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага-IDLO; • Нагояа Их Сургууль; • Монгол дахь Францын элчин сайдын яам; • МУ дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам; • Олон улсын арбитрын шүүх; • Европын Холбооны төлөөлөгчийн газар; • ХБНГУ-ын Вурц Бургийн Их Сургууль; • АНУ-ын Худалдааны яам.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.1 Холбооны Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:	1.1.10.Холбооны дүрмийн 6.6 дугаар зүйлийн 3.2-д заасан гэрээ, хэлцлийг батлагдсан маягтын дагуу бүртгэж, дугаар өгөх, хадгалах, архивлах	Тухай бүр	Шаардлагатай нөхцөлд мэдээллийг ашиглахад бэлэн байлгана.	2023 оны эхний хагас жилд иргэд, аж ахуйн нэгжтэй 35 гэрээ байгуулж бүртгэлжүүлсэн, 4 байгууллага (Монголын татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Цагдаагийн ерөнхий газар, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Улсын Их Хурлын Тамгын газар)-тай хамтран ажиллах санамж бичгийг байгуулан ажиллаж байна.
	1.1.11.Сар, улирлын мэдээ, тайланг хугацаанд нь гаргах, бүртгэл хөтлөх, хяналт тавих, Удирдлагуудад танилцуулах	Тухай бүр	Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтнууд тайлан, мэдээг хугацаанд нь гаргах, тайлагнах	Ажилтнууд, хороодоос тайлан мэдээг авч Холбооны үйл ажиллагааны төлөвлөгөөний нэгдүгээр улирлын биелэлт, хагас жилийн биелэлтийг нэгтгэсэн.
	1.1.12.Тамгын газрын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, хангуулах	Тогтмол	Хэрэгжилтийн дүнг сар тутам гаргаж танилцуулсан байна.	2023 оны эхний хагас жилд Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан, мөн Хөдөлмөрийн дотоод журамд 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулсныг нийт ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн Тээврийн хэрэгсэл ашиглах журмыг шинээр баталж мөрдөн ажиллаж байна.
	1.1.13.Хөдөлмөрийн гэрээ ажлын байрны тодорхойлолтод холбогдох өөрчлөлт оруулах	01 сар	Ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлж үүргийг тодорхой болгох, ажлын бүтээмж сайжирсан байна.	Тамгын газрын бүтэц орон тоо нь Зөвлөлийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар тогтоолоор батлагдсан, Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хөдөлмөрийн гэрээний загварыг шинэчлэн 23 ажилтантай гэрээ байгуулан ажиллаж байна.
	1.1.14.Ажлын цаг ашиглалтад хяналт тавих, ажилласан цагийн бүртгэлийг баталгаажуулах, цалин хөлсийг тогтоосон хугацаанд олгох	Тухай бүр	Ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, цалин тогтоосон хугацаанд олгосон байна.	Шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн дотоод журам сар бүрийн 13, 28-ний өдөр ажилтнуудын цалин хугацаанд нь олгосон. Тайлант хугацаанд 12 удаа цагийн бүртгэл, хорцролтыг гаргасан санхүүд тухай бүр хүргүүлсэн.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.1 Холбооны Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:	1.1.15.Ажлын байрны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ажлын өрөө тасалгааг нэмэгдүүлэх, тохижуулах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	Төсөвт санал оруулж хэрэгжүүлсэн байна. Хөдөлмөрийн нөхцөл сайжирсан байна.	Хуульчдын холбоо нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 4 давхрыг ажлын байрны зориулалтаар түрээсээр ашигладаг бөгөөд Тамгын газрынхаа нийт ажилтнуудын нөөц бололцоог ашиглан 406 тоот өрөөнд олон жил болсон тоосжилт ихтэй дрожийг хулдаасаар сольж тохижуулсан. Мөн Хуульчдын холбооны 402 тоот уулзалт, хурлын танхимыг шинээр тохижуулж, номын сантай болсон. Орчин үетэй хөл нийцүүлэн цахим уулзалт хурал, вебинар сургалт, видео хичээл, зүүм уулзалтад ашиглах зорилгоор ухаалаг дэлгэцийг мөн худалдан авч үйл ажиллагаанд ашиглаж байна. Түүнчлэн энэхүү өрөөг хуульчид хурал уулзалтгүй үед үнэ төлбөргүйгээр уулзалт хийх зэргээр ашиглах боломжийг бүрдүүлж өгсөн. 2023 оны 04-05 дугаар сард цэцэгжүүлэлтийн нэг сарын аяныг зарлаж Тамгын газрын нийт өрөө тасалгааг өөрсдийн нөөц бололцоогоор тохижуулсан.
	1.1.16.Холбооны удирдлагуудад Төрийн ордонд нэвтрэх үнэмлэх олгуулах асуудлыг хариуцан зохион байгуулах	02 сар	Ажил үүргээ явуулахад байгууллагыг төлөөлөх бичиг баримтыг олгуулсан байна.	Холбооны Ерөнхийлөгч болон Тамгын газрын дарга төрийн ордонд нэвтрэх үнэмлэх авсан.
	1.1.17.Ажилтнуудын ажлын үнэмлэхийг шинэчлэн, олгох	1-р улирал	Ажил үүргээ явуулахад байгууллагыг төлөөлөх бичиг баримтыг олгуулсан байна.	Энэ ажил хийгдээгүй.
	1.1.18.Дотоод томилолтоор орон нутагт ажиллах ажилтнуудыг бүртгэж, томилолтын хуудас олгох, бүртгэл хөтлөх, ажилтнуудаас саналыг авч ээлжийн амралтын хуваарь гаргаж батлуулж ажилтнуудад танилцуулах	Тухай бүр	Байгууллагын дотоод ажил хэвийн явагдсан байна.	2023 оны эхний хагас жилд Баянхонгор, Өвөрхангай, Төв аймагт хуульчийн үргэлжилсэн сургалтыг зохион байгуулсан бөгөөд орон нутагт ажилласан ажилтнуудад томилолт олгосон.
	1.1.19.Ажилтнуудын хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж тогтоосон хугацаанд дүгнэж ажиллах	Хагас, бүтэн жил	Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна.	Ажилтнуудтай шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулсан бөгөөд ажлын үр дүнгээрээ бусдыгаа манлайлан ажилласан Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо, Шүүгчдийн хороо, Захиргааны эрх зүйн хороо хариуцсан мэргэжилтэн Ганхуягийн Хосцэцэгт нэг сарын үндсэн цалингийн тавин хувиар тооцон урамшуулал олгосон.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.2. Хуульчдын холбооны хүний нөөц, сургалт, хөгжил, ажилтнуудын нийгмийн асуудлыг зохион байгуулах	1.2.1.Холбооны зөвлөлөөс батлагдсан бүтэц орон тоог бүрдлийг хангаж ажиллах;	01 сар	Хэрэгжилтийг журмын дагуу улирал тутам дүгнэж холбогдох шийдвэр гаргуулсан байна.	Зөвлөлийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар тогтоолоор Тамгын газрын бүтэц орон тоо нь 27 хүнтэй үйл ажиллагаа явуулахаар батлагдсанаас одоо 25 хүн ажиллаж байна, хүүхэд асрах чөлөөтэй ажлын байр нь хадгалагдаж байгаа 4 ажилтан байна.
	1.2.2.Ажиллах хүчний хэрэгцээ, шаардлагыг судлан ажилтнуудын ажлын ачааллыг харгалзан ажил үүргийг тэнцвэржүүлэх;	1-р улирал	Холбогдох шийдвэр гаргуулсан байна.	Тамгын газрын бүтэц орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан Холбооны 19 хороо байгаагаас нэг мэргэжилтэн 2-3 хороо хариуцан ажиллахаар ажил үүргийн хуваарь, ажлын ачааллыг тэнцвэржүүлэн ажиллаж байна.
	1.2.3.Хүний нөөцийн мэдээ, тайлан гаргах, санал боловсруулах, удирдлагад танилцуулах;	Улирал бүр	Удирдлагаар шийдвэрлүүлсэн байна.	Хуульчдын холбооны 10 жилийн ойг тохиолдуулан Тамгын газарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтнуудыг шагналд тодорхойлох саналыг гаргаж салбарын болон төрийн шагналд нэр дэвшүүлсэн Үндэсний их баяр наадмаар шагналыг гардуулсан.
	1.2.4.Ажилтны мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах;	Тухай бүр	Сургалт зохион байгуулж ажилтнуудыг чадавхижуулсан байна.	Хуульчдын холбооны Тамгын газрын ажилтнуудын 2023 оны дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталж дараах сургалтыг зохион байгуулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Албан хэрэг хөтлөлт /АЕГ-тай хамтран/ • Архивын мэдлэг олгох /АЕГ-тай хамтран/ • Хүний эрхийн мэдлэг ойлголт, боловсролыг дээшлүүлэх /ХЭҮК-той хамтран/
	1.2.5.Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, спортын уралдаан, тэмцээн, өдөрлөгийн төсөв, төлөвлөгөөг боловсруулан батлуулж зохион байгуулах;	Жилдээ	Төлөвлөгөө, төсөв батлуулж уралдаан тэмцээн явагдсан байна.	Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран ажиллах гэрээ байгуулж Тамгын газрын ажилтнууд долоо хоног бүрийн даваа гарагт спорт зааланд тоглох нөхцөлийг бүрдүүлж өгсөн. 2023 оны 04 сард Сөүл эмнэлэгтэй гэрээ байгуулан Тамгын газрын нийт ажилтнуудыг Эрүүл мэндийн даатгалаар хийх урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багцад хамруулсан. 2023 оны 05 дугаар сард Хуульчдын өдрөөр Монос групптэй хамтран зохион байгуулсан эрүүл мэндийн өдөрлөг, үзлэг оношлогоонд Тамгын газрын нийт ажилтнуудыг хамруулсан.
	1.2.6.Ажилтнуудад нийгэм, ахуйн тусламж, дэмжлэг үзүүлэх.	Жилээр	Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тусламж дэмжлэг үзүүлсэн байна.	Нэг ажилтны ар гэрийн гачигдалд 200.000 төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон. Бага насны хүүхэдтэй эмэгтэй ажилтнуудын ажлыг цагийг богиносгох, уян хатан болгож өглөө ажил эхлэхээс 30 минут эрт ирсэн бол орой ажил тарахаас 3 минутын өмнө тарах боломжийг олгон ажиллуулж байна. Өөрийн зардлаар мэргэжил, мэргэшил дээшлүүлэн суралцаж байгаа 3 мэргэжилтэнд хичээлд явах, шалгалт өгөх үед хичээлийн болон шалгалтын хуваарийг нь харгалзан ажлын цагийн уян хатан нөхцөлийг тухай бүр бүрдүүлсэн.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.2. Хуульчдын холбооны хүний нөөц, сургалт, хөгжил, ажилтнуудын нийгмийн асуудлыг зохион байгуулах	1.2.7.“Цасны баяр” өдөрлөгийг зохион байгуулах	Жилдээ	Тамгын газрын ажилтнуудын дунд зохион байгуулсан байна.	Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж зохион байгуулаагүй боловч Монголын Хуульчдын холбооны 10 жилийн ойг тохиолдуулан зохион Ерөнхийлөгчийн нэрэмжит шатрын тэмцээнийг 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Хуульчдын холбооны нийт хуульчдын дунд оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, ур чадварыг хөгжүүлэх, туршлага солилцох зорилгоор зохион байгууллаа. Тус тэмцээнд 14 хорооны 42 тамирчин оюун ухаан, ур чадвараа сорин өрсөлдсөн.
	1.2.8.Хуульчдын холбооны 10 жилийн ойг тохиолдуулан “Хуульчдын холбооны шилжин явах цом-2023” зургаан төрөлт спорт тэмцээнийг зохион байгуулах	05 дугаар сар	Спорт тэмцээнийг зохион байгуулсан байна.	Тамгын газар болон Шүүгчдийн хороо хамтран “Хуульчдын холбооны шилжин явах цом-2023” зургаан төрөлт спорт тэмцээнийг 2023.05.11,12,13,14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар С.Энхбаяр Шүүгчийн хорооны дарга, Ш.Жолбарс Тамгын газрын дарга, нарийн бичгийн даргаар Г.Хосцэцэг, Г.Сарангэрэл нар ажилласан. Тэмцээнийг амжилттай зохион байгуулж нийт 450 гаруй тамирчид оролцож авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдсөн.
1.3. Хуульчдын холбооны орон нутаг дахь салбарыг арга зүйн удирдлагаар хангах чиг	1.3.1.Орон нутгийн хуульчдаас иргэд, олон нийтэд үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон үүсч буй хүндрэл, бэрхшээлийг тухайн орон нутгийн удирдлагуудтай хамтран шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах;	Тухай бүр	Хүндрэл бэрхшээлүүдийг гаргаж, шийдвэрлэх арга замыг олж, тодорхой арга хэмжээ авсан байна	info@mglbar.mn хаягаар орон нутгийн хуульчдын тодорхойлолт авах, өргөдөл хүсэлтийг хүлээн авч тухай бүр шийдвэрлэж, хариу өгч байна.
	1.3.2.Орон нутгийн салбарын зохицуулагч нарын чадавхыг нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах, нэгдсэн уулзалт зохион байгуулах	Жилдээ	Сургалтын үр дүнд чадвар дээшилсэн байна.	2023 оны 04 дүгээр сард орон нутгийн салбарын зохицуулагчидтай холбооны удирдлагууд цахим уулзалтыг зохион байгуулж тэдний санал хүсэлт, цагийн үеийн асуудлаар ярилцлаа.
	1.3.3.Хуульчдын холбооны үйл ажиллагааг сурталчилах гишүүд, олон нийт, орон нутагт хүртээмжтэй зохион байгуулах	Жилдээ	Холбооны үйл ажиллагааг орон нутагт сурталчилсан байна.	Хуульчдын холбооны орон нутгийн салбарын зохицуулагч нарыг фэйсбүүк группээр дамжуулан холбооноос зохион байгуулж буй ажиллагааны талаарх зар, мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж байна.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.3. Хуульчдын холбооны орон нутаг дахь салбарыг арга зүйн удирдлагаар хангах чиг	1.3.4.Салбарын зохицуулагч нартай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт тавих, хангуулан ажиллах, ажлын мэдээг нэгтгэх, урамшууллыг олгох	Улирал бүр	Гэрээний биелэлт хангагдаж үр дүнд хүрсэн байна. Харилцан мэдээлэл солилцсон байна.	2023 оны 01, 02 дугаар улирлын тайлан мэдээг авч, салбарын зохицуулагч нарт урамшууллыг тухай бүр олгосон.
	1.3.5.Орон нутгийн салбарыг хууль, Холбооны дүрэмд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх, салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар бусад байгууллагатай харилцахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;	Тухай бүр	Салбарын үйл ажиллагаа хэрэгжсэн байна.	2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр улс орон даяар хуульчийн про-боно өдөрлөгийг зохион байгуулсан бөгөөд орон нутгийн нутгийн захиргааны болон хуулийн байгууллагуудтай хамтран ажилласан. Мөн энэ өдөр 21 аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчидад Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран “Нууцтай байх эрх” сэдвээр хичээл заасан.
	1.3.6.Орон нутгийн салбарын хуульчдын нэгдсэн судалгааг гарган нэгдсэн бүртгэлд бүртгэх	Улирал тутам	Нэгдсэн бүртгэлийн мэдээлэл үнэн зөв бодитой болсон байна.	Орон нутгийн салбарын зохицуулагч нар тайлант хугацаанд 2023 оны 01, 02 дугаар улирлын хуульчдын бүртгэлийг шинэчлэн Тамгын газарт ирүүлснийг хуульчдын нэгдсэн бүртгэлд шинэчлэн бүртгэсэн.
1.4. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчдын холбооны дүрэм, Холбооны бүртгэлийн нэгдсэн журам, холбогдох бусад журамд заасан хяналт тавих чиглэлээр	1.4.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахдаа бүрдүүлсэн баримт бичиг нь үнэн зөв эсэхийг шалгах;	Тухай бүр	Баримтыг бүрдлийг хангуулсан байна.	Хуульчдын холбооны Хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны Бүртгэлийн нэгдсэн журмын 4.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 4.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл нийт 23 дүгнэлт үйлдсэн байна. (Татвар төлөх хугацааг хойшлуулах, хэсэгчлэн төлөх тухай 3, Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгох тухай 10, Гишүүний эрх болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шинэчлэн олгох тухай 1, ХМҮАЭЗ-ийг нөхөн түдгэлзүүлэх тухай 2, Гишүүний эрх болон ХМҮАЭЗ-ийг хүчингүй болгосон тушаалын холбогдох хэсгийг хүчингүй болгох тухай 4, 2022 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцэж МХХ-ны гишүүнээр элсэх өргөдөл гаргасан эрх зүйчдийн бичиг баримтын бүрдлийг хянасан дүгнэлт 1, Хуульчийн шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэх тухай 1, ХМҮАЭЗ-ийг хүчингүй болгох тухай 1).



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.4. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчдын холбооны дүрэм, Холбооны бүртгэлийн нэгдсэн журам, холбогдох бусад журамд заасан хяналт тавих чиглэлээр	1.4.2.Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах багц цаг хангах журмын хэрэгжилтэд хяналт тавих, сургалтын чанар, үнэлгээнд өгсөн дүнг нэгтгэх, танилцуулах	Улирал тутам	Сургалтын чанар сайжирч гомдол, барагдсан байна.	Хуульчдаас ирүүлсэн санал хүсэлтийг харгалзан хуульчийн үргэлжилсэн сургалтын агуулга, чанар, нэр төрлийг олшруулах, сайжруулах зорилгоор Вебинар сургалт, видео хичээлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж видео хичээл, цуврал үндсэн лецүүдийг хийж хуульч өөрийн эрхээр www.mglbar.mn нэвтрэн орж үзэж судалж, кредитээ тооцуулах нөхцөлийг бүрдүүлсэн.
	1.4.3.Сургалтын төлбөрийг хугацаанд нь барагдуулж буй эсэхэд хяналт тавих;	Улирал тутам	Төлбөрийн тооцоогүй болсон байна.	Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам, Албан бус сургалтын журмыг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байгаа бөгөөд Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны хурлын тухай бүр кредит тооцох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна.
	1.4.4.Холбооны нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй гишүүдийн татварын болон сургалтын төлбөр тооцооны мэдээ тайлан гаргах, холбооны цахим хуудаст байршуулах, тэднийг байнгын мэдээллээр хангах ажлыг хариуцан зохион байгуулах, орлогыг бүрдүүлэх;	Улирал тутам	Гишүүний төлбөр тооцоо өр авлага тухай бүр чирэгдэлгүй барагдана.	www.mglbar@mn цахим хуудсыг шинэчлэн хуульчдад үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох, тэднийг байнгын мэдээллээр хангах, холбооны мэдээ мэдээллийг шуурхай хүргэж байна. Түүнчлэн хуульчдын татварын өдөр бүр шүүж, тухай бүр нь татварын үлдэгдлийг санхүүгээс шалгахгаас гадна хуульч өөрөө үүргийн биелэлтийг шалгах тогтолцоог бүрдүүлсэн.
	1.4.5.Холбооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусч үндсэн хөрөнгөөс хасах шаардлагатай эд хөрөнгийн жагсаалт гаргаж актлах устгах	Жилдээ	Зохих журмын дагуу актлаж, орон зайг чөлөөлсөн байна.	Актлах үндсэн хөрөнгийн уагсаалтын гаргаж хяналтын зөвлөлд хүргүүлэн ажилласан.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
<p>1.4. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчдын холбооны дүрэм, Холбооны бүртгэлийн нэгдсэн журам, холбогдох бусад журамд заасан хяналт тавих чиглэлээр</p>	<p>1.4.6.Холбооны нэгдсэн (цаасан болон цахим) бүртгэлийг хөтлөх</p>	<p>Жилдээ</p>	<p>Шинэчлэгдсэн лавлагааг нийтэд мэдээлсэн байна.</p>	<p>Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл түдгэлзүүлэх чиг үүргийн хүрээнд: Нийт 95 хуульчийн эрхийг түдгэлзүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхэд асрах чөлөөтэй- 20 • Өөр ажил албан тушаал эрхэлж байгаа үндэслэлээр-21 • Гадаад улсад суралцаж байгаа үндэслэлээр-6 • Гадаад улсад ажиллаж амьдарч байгаа үндэслэлээр-0 • Эрүүл мэндийн шалтгаанаар-2 • ХЭЗБТХ-ийн 44.7-д заасан үндэслэлээр 46 хуульчийн эрхийг тус тус түдгэлзүүлсэн. <p>Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээх чиг үүргийн хүрээнд нийт 59 хуульчийн эрхийг сэргээсэн бөгөөд нийт хүсэлт гаргасан 275 хуульчид тухай бүр нь тодорхойлолт олгож, Ерөнхийлөгчийн тушаал тус бүр гаргаж, бүртгэлийн программд оруулж, хуульч тус бүрийн мэдээллийг шинэчлэн энэ тухай тэмдэглэгээг хийсэн. Мөн тушаалыг хуульчдад мэйлээр болон хуулбарлан олгосон ба хуульчдын хувийн хэрэгт хуулбарлан хийж баяжуулж байна.</p> <p>Хуульчдын холбооны сайн дурын хороо болох Нотариатын хөгжлийг дэмжих хороог шинээр байгуулж, нэгдсэн бүртгэлд бүртгэн, мэргэжилтэн томилон ажиллуулж байна.</p> <p>Мөн 1130 хуульчийн хувийн хэргийг цахим хэлбэрт шилжүүлж Монголын хуульчдын холбоо (mglbar.mn) цахим хуудаст оруулсан.</p>
	<p>1.4.7.Хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн цаасан бүртгэлийг хөтлөх, мэдээлийн сан бүрдүүлэх</p>	<p>Тухай бүр</p>	<p>Бүртгэл тодорхой болсон байна.</p>	<p>Дүрэм журмын эмхэтгэлийг шинэчлэн хэвлүүлсэн.</p> <p>Мөн Хуульчдын холбооны зөвлөлөөс дараах журмыг шинэчлэн баталсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх журам; • Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах журам; • Төрийн болон төрийн бус байгууллага, хууль зүйн сургууль, бусад этгээдтэй хамтран ажиллах чиглэл; • Судалгааны ажлын журам; • Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам; • Албан бус сургалтын журам; • “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламж, түүнийг олгох журам.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
<p>1.4. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчдын холбооны дүрэм, Холбооны бүртгэлийн нэгдсэн журам, холбогдох бусад журамд заасан хяналт тавих чиглэлээр</p>	<p>1.4.8.Хуульчийн үүргийн биелэлтэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, үйл ажиллагааг жигдрүүлэх.</p>	<p>Жилдээ</p>	<p>Судалгааг зохих журмын дагуу хийсэн байна.</p>	<p>Хуульчдын холбооны Хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны Бүртгэлийн нэгдсэн журмын 4.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 4.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл нийт 23 дүгнэлт үйлдсэн байна. (Татвар төлөх хугацааг хойшлуулах, хэсэгчлэн төлөх тухай 3, Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгох тухай 10, Гишүүний эрх болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шинэчлэн олгох тухай 1, ХМҮАЭЗ-ийг нөхөн түдгэлзүүлэх тухай 2, Гишүүний эрх болон ХМҮАЭЗ-ийг хүчингүй болгосон тушаалын холбогдох хэсгийг хүчингүй болгох тухай 4, 2022 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцэж МХХ-ны гишүүнээр элсэх өргөдөл гаргасан эрх зүйчдийн бичиг баримтын бүрдлийг хянасан дүгнэлт 1, Хуульчийн шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэх тухай 1, ХМҮАЭЗ-ийг хүчингүй болгох тухай 1).</p>
<p>1.5. Төрийн болон салбарын, Холбооны шагналд гишүүд, ажилтнуудыг нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>1.5.1.Төрийн шагналд нэр дэвшиж ирүүлсэн иргэд болон хуульчдын материалыг бүрдүүлж холбогдох газарт уламжлах</p>	<p>Тухай бүр</p>	<p>Салбартаа үр бүтээлтэй ажиллаж Төрийн одо медалийн шагналын болзлыг хангасан хуульчдыг шагнуулахаар уламжилсан байна.</p>	<p>Хуульчдын холбооны 10 жилийн ойг тохиолдуулан Тамгын газарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтнууд, холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, салбартаг тэргүүлэн ажиллаж байгаа дараах хүмүүсийг шагналд тодорхойлж, нэр дэвшүүлж Үндэсний их баяр наадмаар шагнал урамшуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Үйлчилгээний гавьяат ажилтан 1 • Монгол Улсын гавьяат хууль 1 • Хууль зүйн албаны тэргүүний ажилтан хүндэт тэмдэг 6 • Хууль зүй, дотоод хэргийн яамны жуух бичиг 4 • Хуульчдын холбооны Хүндэт тэмдгээр 22. • Мөн Төрийн цол, одон медаль бусад байгууллагын шагналд 22 хуульчийг тодорхойлсон бөгөөд хараахан шийдэгдээгүй байна.
	<p>1.5.2.Салбарын шагналд нэр дэвшүүлсэн иргэдийн материалыг үндэслэн шагналын журмын шаардлагыг хангасан тохиолдолд холбогдох шийдвэр гаргуулан шагналыг олгох</p>	<p>Жилдээ</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан журамд нийцсэн байна.</p>	<p>Хууль зүйн салбарын шагналаар 10 хуульчийг тодорхойлж, шагнаж урамшуулсан.</p>



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.5. Төрийн болон салбарын, Холбооны шагналд гишүүд, ажилтнуудыг нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулах	1.5.3.Хуульчдын холбооны Шагналын журамд заасан болзол шаардлагыг хангасан хуульчдын материалыг хүлээн авч, шийдвэрлүүлэх, шагнал олгох үйл ажиллагааг тухай бүр зохион байгуулах	Тухай бүр	Болзол шаардлага ирүүлсэн материалуудыг судалж, холбогдох байгууллагад уламжилсан байна.	2023 оны эхний хагас жилийн байдлаар Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн тушаалаар 22 хуульчийг шагнасан бөгөөд шагнал гардуулах үйл ажиллагааг 4 удаа зохион байгуулсан.
	1.5.4.Холбооны шагналын тэмдэг, үнэмлэх, хавтас захиалах, нөөц бүрдүүлэх Тэмдэг, үнэмлэх, хавтсыг холбогдох байгууллагад урьдчилан захиалга өгөх.	Жилдээ	Шагналын нөөц бүрдсэн байна.	Зоос гоёл ХХК-д 50 ширхэг тэмдгийн захиалга өгсөн.
1.6. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг заавар, журам, стандартын дагуу хэвийн явуулах	1.6.1.Хуульчдын Холбоо, Тамгын газар, хороодод ирсэн бичиг, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэж, хугацаанд нь хариу хүргүүлэхэд хяналт тавих		Байгууллага, иргэдийн хүсэлтийг шийдвэрлэж, хариу хүргүүлсэн байна.	Үндэсний төв архивт шилжүүлсэн Хуульчдын холбооны 2013-2017 оны байнга хадгалах архивын баримтаас 10994 хуудас материалыг сканердан авч, цахим архив үүсгэсэн. 2023 оны эхний хагас жилд 258 албан бичиг ирүүлсний тухай бүр нь шийдвэрлэж хариу өгсөн.
	1.6.2.Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж 14 хоног тутам мэдээ гаргах, удирдлагад танилцуулах	14 хоног тутам	Хяналт тавьж, дүн мэдээг тухай бүр танилцуулсан байна.	Хариутай бичгийн мэдээ тайлант хугацаанд 4 удаа гаргаж Тамгын газрын хуралд нийт ажилтнуудад болон удирдлагад танилцуулсан.
	1.6.3.Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар бүртгэл хөтөлж, хуулийн хугацаанд шийдвэрлүүлэхэд хяналт тавьж, явцын тайлан гаргана.	Жилдээ	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн байна.	Хуулийн хугацаанд хариу өгөх талаар амаар болон дотоод сүлжээний ээбл программаар тогтмол шаардаж, сануулдаг.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.6. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг заавар, журам, стандартын дагуу хэвийн явуулах	1.6.4.Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас вэб сайтаар ирүүлсэн цахим өргөдөл, гомдол санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар бүртгэл хөтөлж, шийдвэрлэлтийн талаарх явцын тайлан гаргана.	Хугацаа: 14 хоног тутам	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн байна.	info@mglbar.mn ирүүлсэн хүсэлтийг тогтмол хүлээн авч бүртгэн, хариу өгч ажиллаж байна.
	1.6.5.Холбооноос явуулж буй албан бичгийн бүрдлийг хянаж, огноо, дугаар өгч, хадгална.	Хугацаа: Жилдээ	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар болон албан хэрэг хөтлөлтийн стандарт зөрчигдөөгүй байна.	Албан бичиг, өргөдлийн хариуг Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг мөрдөн ажиллаж байна. Тайлант хугацаанд Холбооноос 605, хороодоос 61 албан бичгийг боловсруулан албажуулж холбогдох газарт нь өгсөн.
	1.6.6.Өөрийн эрхэлсэн ажилтай холбоотой баримт бичиг (явуулсан бичиг, төлөвлөгөө, тайлан, мэдээ, тушаал, дүрэм журам, гэрээ, илтгэх хуудас гэх мэт)-ийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулах	Тухай бүр	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөх	Архивын Ерөнхий газартай хамтран Албан хэрэг хөтлөлт, баримт бичиг боловсруулах стандарт, Архивын мэдлэг олгох 2 удаагийн сургалтыг Тамгын газрын ажилтнуудад зохион байгуулсан.
1.7. Архивын үйл ажиллагааг зааврын дагуу хэвийн явуулах	1.7.1.Холбооны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулан батлуулах, ажилтнуудад танилцуулах	1-р улирал	ХХНЖ-ын дагуу ажилтнууд 2021 онд үүсч хөтлөгдөх баримтыг зөв зохион бүрдүүлсэн байна.	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын төслийг боловсруулсан.
	1.7.2.2022 үүсч хөтлөгдсөн баримт бичгийг зааврын дагуу архивт нэгж бүдүүлж, бүртгэлээр хүлээн авах, бүртгэлжүүлэх	1-р улирал	Баримтуудыг хүлээн авч, Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу бүртгэл хөтлөх	Хуулбар үнэн тэмдэглэгээг 26 албан бичигт дарсан.
	1.7.3.Байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг явуулах	Жилдээ	Байгууллагын архивын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна.	Баримт бичиг нягтлан шалгах комиссыг шинэчлэхээр болсон.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.7. Архивын үйл ажиллагааг зааврын дагуу хэвийн явуулах	1.7.4.Өөрийн эрхэлсэн ажилтай холбоотой тухайн жилд боловсуулсан, үүсэж хөтлөгдсөн бүхий л баримт бичгийг архив зүйн үүднээс хугацаанд нь үдэж хавтаслан байгууллагын архивт шилжүүлэх	1-р улирал	Архивын үйл ажиллагааг хэвийн явуулах	Тамгын газрын ажилтнууд 2022 онд үүсэж хөтлөгдсөн баримт бичгийг үдэж хавтаслан байгууллагын архивт 45 хадгаламжийн нэгжийг бүртгэл үйлдэж шилжүүлсэн.
1.8. Хуульчид болон Хуульчдын холбооны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, таниулах	1.8.1.Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах.	01-03 сард	Хуульчдыг олон нийтэд сурталчлах, хуульчийн үүргийг олон нийтэд таниулж, о Хуульчдын холбооны үйл ажиллагааны мэдээ мэдээлэл олон нийт болон хуульчдад нээлттэй, түргэн шуурхай хүрдэг болно. олон нийт зөв мэдээлэлтэй болно.	Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Энэ хүрээнд 60 сэтгүүлдэд хууль эрх зүй, хүний эрхийг мэдлэг олгох сертификаттай сургалтыг зохион байгуулсан.
	1.8.2.Хуульчдыг олон нийтэд таниулах хүрээнд хөрөг нэвтрүүлэг, нийтлэлийн буланд оролцуулах, Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгүүлэх.	Жилдээ	Хуульчдыг олон нийтэд сурталчлах, хуульчийн үүргийг олон нийтэд таниулж, олон нийт зөв мэдээлэлтэй болно.	Легалдатагаас бэлтгэн хүргэдэг "legaltalk" подкастын энэ удаагийн дугаараар Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталсан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон уг хуулийг дагалдуулан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооны Тэргүүн Т.Мөнх-Эрдэнэтэй ярилцсан.
	1.8.3.Хууль эрх зүй, нийгмийн асуудлаар социал пост бэлтгэж нийтлэх.	Жилдээ	Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд түлхэц болно.	www.mglbar цахим хуудсыг инэчлэн илүү боловсронгуй болгон ашиглалтад оруулсан бөгөөд Хуульчдын холбооны үйл ажиллагаанаас гадна хуульч, өмгөөллийн нөхөрлөллүүд, хуулийн байгууллагууд мэдээл мэдээллээ байршуулж, сурталчлах боломжтой болсон.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.9. Гишүүдэд Холбооны мэдээллийг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх	1.9.1.Холбооноос зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг боловсруулж, олон нийтэд сурталчлах	Жилдээ	Холбооны үйл ажиллагааг олон нийтэд хүргэх	Тайлант хугацаанд www.mglbar.mn цахим хуудаст 199, facebook пэйжд 186 мэдээ мэдээллийг бэлтгэн иргэд олон нийтэд түгээсэн.
	1.9.2.Хороодын сонгуулийг зохион байгуулах	тухай бүр	Хороодод дэмжлэг үзүүлсэн байна.	Тамгын газраас хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор www.mglbar.mn цахим хуудсаар Хуульчдын холбооны чиг үүргийн болон сайн дурын хороодын сонгуулийг зарлаж, хороодын гишүүдийн 80 гаруй хувь нь шинэчлэгдсэн.
	1.9.3.Мэргэшсэн чиглэлээр хэвлэл мэдээлэлд тайлбар өгөх, зөвлөгөө мэдээлэл өгөх хуульчдын нэрсийг жагсаалт гаргах	Жилдээ	Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг түгээх	Тайлант хугацаанд хараахан хийгдээгүй.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
<p>1.10. Хуульчдын холбооны Хяналтын зөвлөлийг байгуулах, үйл ажиллагаа явуулах</p>	<p>1.10.1.Хяналтын зөвлөлийг байгуулж, тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>Жилдээ</p>	<p>Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа, холбогдох, дүрэм журмын дагуу явуулахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>Хуульчдын холбооны Хяналтын зөвлөлийн шүүгчийн төлөөлөл 2, өмгөөлөгчийн төлөөлөл 1 гишүүний бүрэн эрхийн хугацаа 2022 оны 12 дугаар сарын дууссантай холбогдуулан 2 гишүүнтэй үлдсэн Хяналтын зөвлөл үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болсон. Иймээс Хяналтын зөвлөлд нэр дэвшсэн гишүүдийг Зөвлөлд танилцуулах, томилох ажлыг Тамгын газраас 2023 оны 2 дугаар сараас 4 дүгээр сар хүртэлх хугацаанд зохион байгуулж Хуульчдын холбооны Шүүгчдийн хороонд Хяналтын зөвлөлийн гишүүнд 2 шүүгчийн төлөөллийг нэр дэвшүүлэх тухай 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 1/189 тоот албан бичгийг хүргүүлж, Шүүгчдийн хорооны 2023 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 2/38 тоот албан бичгээр Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Төмөрхуягийн Жавхлантөгс, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Довдонгийн Цэрэндолгор нарыг нэр дэвшүүлснийг Хуульчдын холбооны Зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилсон.</p> <p>Мөн Өмгөөлөгчдийн хороонд Хяналтын зөвлөлийн гишүүнд өмгөөлөгчийн төлөөллийг нэр дэвшүүлэх тухай 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1/190 тоот албан бичгийг хүргүүлж, Өмгөөлөгчдийн хорооны 2023.03.23-ны өдрийн 2/43 тоот албан бичгээр өмгөөлөгч Шаалавын Эрдэнэчимэг, Жадамбаагийн Эрдэнэбилэг, Магсарын Нармандах нарын нэрийг дэвшүүлснийг Зөвлөлд танилцуулсан. Зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит бус хурлын 09 дүгээр тогтоолоор дараагийн Зөвлөлийн хуралд нэг өмгөөлөгчийн төлөөллийг нэр дэвшүүлэхийг үүрэг болгосон. Иймээс Өмгөөлөгчдийн хорооноос 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 2/47 тоот албан бичгээр өмгөөлөгч Жадамбын Эрдэнэбилэгийг Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлснийг 2023 оны 4 дүгээр сарын 28-ны Зөвлөлийн ээлжит хуралд танилцуулж мөн хурлын 18 дугаар тогтоолоор томилсон байна.</p> <p>2023 оны эхний хагас жилд Хяналтын зөвлөл 1 удаа хуралдаж, Хяналтын зөвлөлийн дагыг томилох тухай №01 тогтоол гаргасан байна. Тодруулбал, МХХ-ны Хяналтын зөвлөл 4 гишүүнтэй болсон тул шинээр бүрэлдсэн зөвлөлийн хурлыг хуралдуулах ажлыг Тамгын газраас зохион байгуулж 2023.04.05-ны өдөр хуралдав. Хяналтын зөвлөлийн ээлжит бус хурлаар зөвлөлийн даргыг сонгож Зөвлөлөөр батламжлуулах, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах асуудлыг хэлэлцэв. Хяналтын зөвлөлийн хуралд оролцсон 4 гишүүний дэмжсэн саналаар Т.Жавхлантөгсийг Хяналтын зөвлөлийн даргаар сонгосныг МХХ-ны Зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 28-ны Зөвлөлийн ээлжит хурлын 18 дугаар тогтоолоор томилсон.</p>



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
1.11. Хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтыг зохион байгуулах	1.11.1.Хуульчийн үргэлжилсэн сургалт, албан бус сургалтуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Жилдээ		<p>Ханнс зайделийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2 видео хичээлийг бэлтгэсэн.</p> <p>Хуульчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийг таниулахад чиглэсэн 2 Үндсэн лекцийн агуулгаар видео бэлтгэн www.mglbar.mn цахим хуудаст байршуулаад байна.</p> <p>Интэрнетэд суурилсан зайн сургалт буюу вебинар 3 сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Хуульчийн үргэлжилсэн сургалтыг Өвөрхангай аймагт 2023 оны 05 дугаар сарын 03, 04-ний өдөр, зохион байгуулж 35 хуульч, Баянхонгор аймагт 05 дугаар сарын 05, 06-ны өдөр зохион байгуулж 38 хуульч, Төв аймагт 2023 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдөр зохион байгуулж 40 хуульч хамрагдав.</p> <p>2023 оны 03 дугаар сарын 30, 31-ний өдөр хуульчийн үргэлжилсэн сургалтыг зохион байгуулав. Тус сургалтыг багц цаг нөхөн тооцуулах боломжтойгоор зохион байгуулсан.</p> <p>2023 оны эхний хагас жилд хуульчийн үргэлжилсэн 19 сургалтыг танхимаар зохион байгуулсан.</p> <p>Мөн албан бус сургалтын гадаад дотоодын байгууллагуудтай хамтран зохион байгуулав.</p>
1.12. Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	1.12.1.Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах дэд ажлын хэсгийг байгуулж, зохион байгуулах, гэрчилгээ олгох, тангараг өргүүлэх, нэгдсэн бүртгэлд бүртгэх гэх мэт	4-р улирал	Хуульчийн мэргэжлийн шалгалтын хороонд дэмжлэг үзүүлэн ажиллах	Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны сонгуулийг Тамгын газраас зохион байгуулсан.



ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТ
<p>1.13. Хуульчдын дуу хоолойг нийгэмд хүргэх, тэдний үйл ажиллагааг дэмжих нөлөөллийг ажлыг зохион байгуулах</p>	<p>1.13.1.Хуульчдын форум, хэлэлцүүлэг, оны шилдэг хуульч шалгаруулах Фемида арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Жилдээ</p>	<p>Холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.</p>	<p>“Хуульчдын өдөр”-ийг тохиолдуулан нээлттэй хаалганы өдөрлөгийг хуулийн байгууллагууд /Хууль зүйн туслалцааны төв, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын Нотариатчдын танхим зэрэг/-тай хамтран хуульчдын талбайд зохион байгуулсан. Мөн энэ үеэр Монос групптэй хамтран Холбооны гишүүн хуульчдад зориулж эрүүл мэндийн өдөрлөг, үзлэг оношлогоог зохион байгуулж 120 гаруй хуульч тус өдөрлөгт оролцсон.. Хуульчдын төгөлтэй болох санаачлагыг хуульчдын холбооны удирдлагууд гаргасантай холбогдуулан 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд гишүүн хуульчдынхаа дэмжлэгтэйгээр 200 ширхэг мод тарьсан. Хуульчдын форум, оны шилдэг хуульч шалгаруулах Фемида арга хэмжээг 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.</p>
<p>1.14. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих</p>	<p>1.14.1.Хуулийн этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах</p>	<p>Жилдээ</p>	<p>Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьсан байна.</p>	<p>Хуульчдад мэдээлэл хүргэх зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр СМА-аас ирүүлсэн ФАТФ-ын саарал жагсаалтад 2023 оны 02 дугаар сарын байдлаар багтсан улсуудын жагсаалтыг, зайны хяналт шалгалтын асуулгын хамт масс мэйл хүргүүлсэн. СМА-наас мэргэжлийн холбоодод зохион байгуулсан хянан шалгах үйл ажиллагааны сургалтад 2023 оны 04 сарын 28, 2023 оны 06 сарын 13,14-ний өдрүүдэд хамрагдсан.</p>



МОНГОЛЫН
ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО

ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠨ
ᠬᠤᠭᠤᠯᠠᠨ